

“Амьдралын боловсрол” олгох ТӨСЛИЙН НЭЭЛТ боллоо

Б.БЯМБАСҮРЭН, IKON.MN

2015 ОНЫ 12 САРЫН 16

ЖИРГЭ

13

IKON.MN



Японы Жичи Анагаах ухааны сургууль, ЖАЙКА-гаас хэрэгжүүлж буй “Өсвөр үеийнхнийг эрүүл аж төрөх дадалд суралцуулах тогтвортой систем байгуулах төсөл”-ийн нээлтийн ажиллагаа өнөөдөр Улаанбаатар зочид буудалд боллоо.

Төслийн хамтран ажиллагчаар БСШУЯ, АШУҮИС, НЭМГ, Сүхбаатар дүүргийн Эрүүл мэндийн төв, Сүхбаатар дүүргийн 71 дүгээр сургууль оролцож байна.

Уг төслийн гол зорилго нь

Сургалтын нэгдсэн төлөвлөгөөний дагуу өсвөр насны үе тэнгийн зөвлөхүүдийг бэлтгэж, тэдэнд эрүүл амьдралын хэв маягийг хэвшүүлэх, улмаар найз нөхөд, гэр бүлийнхэн, дүүрэг хорооныхоо оршин суугчдыг эрүүл зөв амьдрахад нь туслах юм.

Төслийн хэрэгжүүлэх болсон шалтгаанаа зохион байгуулагчид “Өсвөр насны охидын жирэмслэлт, бэлгийн замын халдварт өвчнөөр өвчилсөн тохиолдол олон бүртгэгдсэн, хүүхдүүдэд нөхөн үржихүйн мэдээлэл хомс, нэгдсэн тогтолцоо байхгүй” зэрэг үндэслэлүүдийг тавьж байсан юм.

2015-2019 он хүртэл хугацаанд хэрэгжих энэ төслийн эхний үйл ажиллагааг 71 дүгээр сургууль дээр хийх бөгөөд цаашид хамрагдах сургуулиудын тоог нэмэгдүүлэх аж.

Үйл ажиллагааг нээж хэлсэн үгэндээ БСШУЯ-ны Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Д.Эрдэнэчимэг “Цаг үеэ олсон, үр нөлөөгөө өгөх төсөл гэж БСШУЯ-наас тэмдэглэн хэлэхэд таатай байна. Өнөөдөр Монголын өсвөр үеийнхний дунд хүсээгүй жирэмслэлт, БЗХӨ тусах байдал, амьдралын буруу хэвшлээс болж өвчин эмгэгт өртөх байдал анхаарал татсан асуудал болж байгаа.

Үүнийг шийдвэрлэхэд Эрүүл мэндийн яам, эмнэлэг, эмч нараас илүү цэцэг эхчүүд, сургууль онцгой үүрэг гүйцэтгэх шаардлагатай. Энэ асуудалд хариу өгөх их санаачлагын эхлэлийг тавьсан төсөл хэрэгжих гэж байгаад нэн таатай байна” гэв.

ЖАЙКА-ын Монгол дахь төлөөлөгчийн газрын дага Сато Мүцүми “Энэ удаагийн төсөл 10-19 насны өсвөр үеийнхний дунд хэрэгжинэ. Нэгэн үед Японд энэ насны хүүхдүүдийн хувьд хүсээгүй жирэмслэлт, бэлгийн замын өвчин нэмэгдэж хандлагатай болсон. Тиймээс нөлөөллийн үйл ажиллагаа хийснээр нэмэгдэлтийг багасгасан туршлагатай.

Төслийн хүрээнд авч хэрэгжүүлэх арга нь үе тэнгийн зөвлөхүүдийг бэлдэх юм. Өмнө энэ аргыг Японы нийгэмд өргөнөөр хэрэглэж байсан. Одоо Японы боловсролын салбарт энэ аргыг өдөр тутамдаа хэрэглэж байна.

Монголд дээрх асуудал хурцадмал байдалтай байгаа гэж сонссон.

Тиймээс энэ нь залуучуудад зориулсан үр дүнтэй арга байх болов уу гэж бид найдаж байна” хэмээв.